

“БИ ЭС АЙ” ХХК

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМЫН НУТАГТ ОРШИХ
“БАНУУН ХАРГАНТЫН” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ АРГААР
АШИГЛАХ ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

ГАРЧИГ

ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	2
1.1 Төслийн нэр.....	2
1.2 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл.....	2
1.3 Төслийн хүчин чадал.....	2
1.4 Уурхайн дэд бүтэц.....	2
1.5 Уурхайн ажиллах горим.....	2
1.6 Усан хангамж.....	3
1.6 Цахилгаан хангамж.....	3
2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ ОРЧМЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ.....	4
2.1 Төсөл хэрэгжих талбайн байршил , физик газар зүйн нөхцөл.....	4
2.2 Төсөл хэрэгжих талбайн хөрсөн бүрхэвч.....	6
2.3 Төсөл хэрэгжих талбайн ургамлан нөмрөг.....	7
2.4 Төсөл хэрэгжих талбайн гадаргын болон гүний ус.....	8
2.5 Төсөл хэрэгжих орон нутгийн нийгэм эдийн засагын байдал.....	9
3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛИЙН.....	11
3.1 АГААРЫН ЧАНАРТ НӨЛӨӨЛӨЛ ҮҮСГЭХ ЭХ ҮҮСВЭРҮҮД.....	11
3.2 ХӨРСӨН БҮРХЭВЧИНД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ.....	11
3.3 ГАДАРГЫН БОЛОН ГҮНИЙ УСАН ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ.....	12
3.4 Төслийн болзошгүй сөрөг нөлөөлөл үргэжлэх хугцаа ,эрчим.....	12
4. 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	1
БҮЛЭГ5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	2
БҮЛЭГ6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	7
БҮЛЭГ7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗЫН БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	8
БҮЛЭГ8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	9
БҮЛЭГ9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	9
БҮЛЭГ10. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	10
БҮЛЭГ11. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	11
БҮЛЭГ12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР.....	13
БҮЛЭГ13. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР АВАХ АРГА ХЭМЖЭЭ.....	15
БҮЛЭГ14. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ОРОЛЦОГЧ, СОНИРХОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ХУВААРЬ.....	17

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт № 1 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл.....	2
Хүснэгт № 2 Байгууламжийн жагсаалт.....	2
Хүснэгт № 3 . Дизель генераторуудын үндсэн хэрэглэгчид.....	3
Хүснэгт № 4 талбайн координат.....	4
Хүснэгт № 5 магадлан жагсаах арга.....	12
Хүснэгт № 6 БОМТ-ний зардалын задаргаа.....	1

ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 Төслийн нэр

Баянхонгор аймгийн Өлзийт сумын нутаг дэвсгэрт орших “Баруун Харгант” алтны шороон ордыг ашиглах төсөл.

1.2 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

Хүснэгт № 1 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

Төсөл хэрэгжүүлэгч	“Би Эс Ай” ХХК
Улсын бүртгэлийн дугаар	90190913029
Регистрийн дугаар	5035503
Хаяг	Монгол, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энхтайвны өргөн чөлөө, 12/1, 16 тоот.
Утас	99113968

1.3 Төслийн хүчин чадал

Ил уурхайн хүчин чадал: Баруун Харганат алтны шороон ордоос жилд 37.97 мян.м³ элс олборлох хүчин чадал бүхий ил уурхайг ажиллуулахаар төлөвлөв. Нийт үйлдвэрлэлийн нөөц 63.87 мян.м³ элс байна. Төсөл боловсруулагчдын зүгээс MV-021465 тоот ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд хамаарах Баруун Харганат алтны шороон ордын нөөцийг ашиглалтын эхний 1-р жилд 37.97 мян.м³ элс, 2-р жилд 25.89 мян.м³ элс олборлохоор 2 жилийн хугацаанд төлөвлөв. Ашиглалтын хугацаанд 322.51 мян.м³ хөрс хуулж, 63.87 мян.м³ элс олборлож, шлихээр 34.24 кг, химийн цэврээр 32.97 кг алт олборлохоор байна.

1.4 Уурхайн дэд бүтэц

Уурхайн барилга байгууламж

Ажилчдын хотхон нэг дор 56 хүн байрлах ба нэг ээлжинд 28 хүн 12 цагийн 2 ээлжээр байрлана. Ажилчид таваараа амьдрах ажилчдын байр, конторын байр, хувцас угаалгын газар, бие засах болон ажилчдын халуун усны газар, дизелийн байр, агуулах, харуулын байр зэрэг барилга байгууламжууд байна. Агуулах, түлшний агуулах зэрэг байгууламжууд байна.

Хүснэгт № 2 Байгууламжийн жагсаалт

№	Барилга байгууламж	Төрөл	Тоо
1	Дизелийн байр	сэндвич	1
2	Уурхайн хотхоны байр	сэндвич	4
3	Цайны газар	Гэр	1
4	Халуун усны барилга	контейнер	1
5	Харуулын байр	сэндвич	1
	Түлшний агуулах		1
	Хэсгийн дүн		9

1.5 Уурхайн ажиллах горим

Уурхайн ажиллах горимыг уурхайн хүчин чадал, жилд гүйцэтгэх уулын ажлын хэмжээ, хэрэглэгчдийн хэрэглээний хугацаанаас хамааруулан жилд 05 сараас 11 сар хүртэл буюу 6 сарын хугацаанд Ил уурхай долоо хоногт амралтгүй 12 цагийн 2 ээлжээр ажиллана. Уурхайн жилд ажиллах хоног 180 хоног, буюу 2880 цаг ажиллана.

1.6 Усан хангамж

Унд ахуйн болон технологийн хэрэгцээний усыг уурхайд байрлах 5 худгаас хангана. Худгуудын нийлбэр ундарга 15л/сек байна. Судалгааны талбайд хэрэглэгдэх усны хэрэгцээ нь:

- Унд, ахуйн хэрэгцээний ус
- Ногоон байгууламж усалгаа
- Замын усалгаа
- Үйлдвэрийн хэрэглээнд

Байгаль орчныг хамгаалах.цэвэр усны нөөцийг хэмнэх зорилгоор үйлдвэрийн технологийн усан хангамжинд хэрэглэгдэх усыг хуримтлуулж, цэвэршүүлэх замаар эргүүлэн ашиглах юм.

1.6 Цахилгаан хангамж

Төслийн цахилгаан хангамжийн эх үүсвэрийг DENYO маркийн дизель генераторуудаар шийдвэрлэнэ. Баруун Харганатын алтны шороон ордод ажиллах дизель генераторуудын техникийн үзүүлэлтийг дараах хүснэгтүүдэд үзүүлээ.

Хүснэгт № 3 . Дизель генераторуудын үндсэн хэрэглэгчид

№	Үзүүлэлт	Дизель генераторын марк	Ажиллах тоо, ш
1	Ил уурхай угаан баяжуулах хэсэг	DENYO DCA 150USK	1
2	Ажилчдын хотхон, контор, засварын хэсэг	DENYO DCA 100ESI	1
3	Уурхайн гэрэлтүүлэг, Нөөцөд	DENYO DCA 150USK	1
Нийт		-	3

**2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ ОРЧМЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ
ТОДОРХОЙЛОЛТ**

2.1 Төсөл хэрэгжих талбайн байршил ,физик газар зүйн нөхцөл


Улаанбаатар хотоос 665 км, Баянхонгор аймгийн Өлзийт сумын нутагт Түйн голын сав газарт байрлана. Баянхонгор аймгийн төвөөс 25 км, Өлзийт сумын төвөөс 14 км зайд байрлана.

Хүснэгт № 4 ТАЛБАЙН КООРДИНАТ

Утраг	Өргөрөг
100°54'17.45"E	45°59'59.64"N
100°54'17.45"E	45°59'39.40"N
100°55'41.35"E	45°59'39.40"N
100°55'41.35"E	45°59'24.00"N
100°56'18.00"E	45°59'24.00"N
100°56'18.00"E	45°58'55.00"N
100°59'19.37"E	45°58'55.00"N
100°59'19.37"E	45°57'23.00"N
100°58'11.45"E	45°57'23.00"N
100°58'11.45"E	45°57'2.00"N
100°57'21.45"E	45°57'2.00"N
100°57'21.45"E	45°57'20.00"N
100°55'40.00"E	45°57'20.00"N
100°55'40.45"E	45°57'1.00"N
100°55'15.00"E	45°57'1.00"N
100°55'15.00"E	45°56'17.00"N
100°55'54.45"E	45°56'17.00"N
100°55'54.00"E	45°56'45.30"N
100°56'31.00"E	45°56'45.30"N
100°56'31.00"E	45°57'16.40"N
100°57'17.40"E	45°57'16.40"N
100°57'17.40"E	45°56'59.40"N
45°56'59.40"N	45°56'59.40"N
100°56'41.00"E	45°56'13.00"N
100°56'4.80"E	45°56'13.00"N
100°56'4.80"E	45°55'47.50"N
100°57'25.50"E	45°55'47.50"N
100°57'25.50"E	45°56'18.60"N
100°57'51.80"E	45°56'18.60"N
100°57'51.80"E	45°56'38.00"N
100°58'18.00"E	45°56'38.00"N
100°58'18.00"E	45°57'18.80"N
100°59'19.37"E	45°57'18.80"N
100°59'19.37"E	45°56'56.11"N
101° 0'0.57"E	45°56'56.11"N
101° 0'0.58"E	45°55'32.65"N
100°56'38.80"E	45°55'32.65"N
100°56'38.80"E	45°55'16.20"N
101° 0'0.58"E	45°55'16.20"N
101° 0'0.58"E	45°54'60.00"N
100°57'12.32"E	45°55'12.35"N
100°57'12.32"E	45°55'12.35"N

БАЯНХОНГОР АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМЫН НУТАГТ ОРШИХ “БАРУУН ХАРГАНТЫН” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

100°54'37.01"E	45°55'12.35"N
100°54'37.01"E	45°56'45.65"N
100°54'20.53"E	45°56'45.65"N
100°54'20.53"E	45°57'43.04"N
100°53'51.33"E	45°57'43.04"N
100°53'51.33"E	45°58'15.52"N
100°53'0.52"E	45°58'15.52"N
100°53'0.52"E	45°59'59.64"N



Зураг № 1 .Төслийн талбайн байрзүйн зураг

Төслийн талбайн Физик газарзүй: Хэнтийн нуруу ба түүний гол салбаруудын тойрог нь Хэнтийн гол нуруу, Бага Хэнтий, Их Хэнтийн нуруу, тэдгээрийн томоохон салбаруудыг багтаана. Эндхийн үнэмлэхүй өндөр нь 2000-2500 метр бөгөөд хамгийн өндөр цэг нь Асралт Хайрхан юм. Хэнтийн нурууд ялангуяа Бага Хэнтийн нурууны хажуу нь хоорондоо адилгүй, хойт хажуу нь маш эгц бөгөөд урт, харин өмнө хажуу нь нилээн налуувтар болно. Гэвч хоёулаа нураг асгаар бүрхээстэй байна. Хажуугийн дээд хэсэгт шаталсан хэдэн дэнж тодорхой үзэгдэнэ.

Уул, хотгорууд бүхий ландшафтын бүтцийн хувьд нэлээд нарийн төвөгтэй юм. Энд уулын ар, өвөр хажуугийн ойт хээр, уулын хуурай хээр, уулын ой, уулын хээрийн ландшафт алаглан тогтжээ. 2.2 Төсөл хэрэгжих орон нутгийн уур амьсгал
Төслийн талбай орчимд зуны улиралд эх газрын дулаан хуурай агаар зонхилдог. Иймээс орох хур тунадас ихэнхдээ аадар шинжтэй байдаг. Намар хур тунадас багасаж, цочир


БАЯНХОНГОР АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМЫН НУТАГТ ОРШИХ “БАНУУН ХАРГАНТЫН” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

хүйтрэлт 8 дугаар сарын сүүлч, 9 дүгээр сарын эхээр ажиглагдсан 10 дугаар сарын сүүлч, 11 дүгээр сарын эхээр өвлийн нөхцөлдөө шилжин ордог.

Агаарын температур: Баянхонгор аймгийн нутаг нь хангай, тал хээр, говь хосолсон уудам дэлгэр нутагтай тул дулаан хүйтний хэлбэлзэл ихтэй сүүлийн жилүүдийн байдлаар нийт нутгаар жилийн дундаж агаарын температур дундажаар 2.00C дулааран хэдий ч улирлаар нь авч үзвэл: Ихэнх нутгаар өвлийн улиралд 1.4-өөс 2.5 градус, хавар зуны улиралд 0.2-оос 1.0 градусаар дулаарсан, нутгийн өмнөд хэсгээр өвлийн улиралд -0.2-оос -2.0 хүйтэрсэн хэдий ч зуны улиралд 2.0 градусаар дулаарч ажиглагдаж байна.

2.2 Төсөл хэрэгжих талбайн хөрсөн бүрхэвч

Баянхонгор аймгийн Өлзийт сумын нутаг нь хөрс газарзүйн хувьд сав газрын хойт хэсэг нь Хэнтийн нурууны төв хэсгийн уулын тундрын болон уулын нугын хөрсний тойрогт, нутгийн дунд болон түүнээс хойш хэсэг нь Хэнтийн нурууны зүүн ба баруун хэсгийн салбар уулсын уулын хар хүрэн ба хээрийн хар хүрэн хөрсний тойрогт, хэсэг нь хуурай хээрийн бүсийн ухаа гүвээт, уудам хөндийн хүрэн хөрсний тойрогт ордог.



Зураг № 2. Төслийн талбайн хөрсний зураг


Төслийн талбайд нам уулсаар тогтворжсон, элювийн нимгэн хурдасаас бүрдсэн, сул хөгжилтэй хүрэн хөрс тохиолдоно. Энэ хэв шинжийн хөрс нь үе давхарга гүйцэд биш (А-АС), зузаан нь 25-30 см-ээс хэтрэхгүй байдаг онцлогтой. Нам өндөртэй уулс болон нөхцөлд тогтворжих бөгөөд түүний ялзмаг хуримтлалын (А) давхаргын доод хэсэгт 5-10 см нимгэн, сайр чулуу ихтэй, сийрэг сул тогтоцтой үе үүссэн байна. Ургамал нөмрөгийн бүрхэц нь 30-50% байна. Хөрсний чийгийн хангамж төдий л сайн биш, доод үе давхарга голдуу хуурай байна.



Зураг № 3. Төслийн талбайн зураг

2.3 Төсөл хэрэгжих талбайн ургамлан нөмрөг

Баянхонгор аймгийн Өлзийт сумын нутаг нь ой модгүй, зарим хэсэгтээ бутлаг болон голын хайлаас, ховроор бургасан төгөлтэй. Хотгор хонхор, нам дор газруудаар нь олон төрөл өвслөг ургамал ургана. Бүс нутгийн хойд, зүүн хойд хэсгээр Аллювийн нугын төрлийн ургамал зонхилох бөгөөд уулсын эгц налуу, хадархаг, өндөрлөг газруудаар нь ургамлын бүрхэвч тачир байна. Байдраг голын татам, голын тохой буланд хайлаас, бэсрэг хус, улаан бургас зэрэг модлог ургамлын цөөн төрлүүд ургана.



Зураг № 4. Төслийн талбайн ургамалжилтийн зураг


Зургаас үзэхэд ургамлын массын болон ургамлын төрөл зүйлийн хувьд өмнөх жилүүдтэй харьцуулбал энэхүү хэсэгт харьцангуй баян байгаа нь тухайн жилийн уур

БАЯНХОНГОР АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМЫН НУТАГТ ОРШИХ “БАРУУН ХАРГАНТЫН” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

амьсгалын нөхцөл байдалтай холбогдож байна. Төслийн талбай нь газар ашиглалтын ангиллаар ХАА-н газар, бусад газар гэсэн ангилалд хамаарагддаг байна.


2.4 Төсөл хэрэгжих талбайн гадаргын болон гүний ус

Баянхонгор аймгийн Өлзийт сумын нутаг нь Баруун Харгант 1962 м, Зүүн Харгант 2046,9 м, Бага Алаг уул 1898,7 м зэрэг өндөрлөгүүд байрлах ба Баруун Харгантын Арын, Баруун Харгантын Өврийн хөндий, Сангийн далайн сайр – хөндий, түүний цутгал – хуурай сайрууд Түйн голтой нийлж урсана. Геологи-хайгуулын Баянбүрд талбайн баруун хойд үзүүрээс 3-5 км зайд Шаргалжуутын гол урсаж Түйн голтой нийлнэ.



Зураг № 5. Төслийн гадаргын усны зураг

Зургаас үзэхэд төслийн талбайн хамгийн ойр гадаргыг ус нь Түйн гол байна. Талбай нь Түйн голын усны ай савд багтах ба голын сайраас 500 м зайд байрлана.



Зураг № 6. Төслийн гүний усны зураг

Төслийн талбайн орчим гүний ус байхгүй ба Өлзийт сумын гар худгаас шинэжилсэн үндсэн үзүүлэлтүүдэд ерөнхий хатуулаг болон магнийн ионы агууламж нь “Ундны усны чанарын стандарт MNS900:2018”- д заасан хэмжээнээс их байгаа тул хүний унданд тохиромжгүй, зөөлрүүлж хэрэглэх шаардлагатай байна.

2.5 Төсөл хэрэгжих орон нутгийн нийгэм эдийн засагын байдал

Өлзийт сумийн газар нутаг: Сумын нутаг дэвсгэрийн ихэнх нь далайн түвшнээс дээш 1500-2000м өргөгдсөн бөгөөд хамгийн өндөрлөг газар болох Баяндаваа 3300 м, нам дор газар болох Хавхаастай 1300 м өргөгдсөн байдаг. Хангайн нурууны салбар уулсын дунд цагаан нурууд, удам тал хээр, уулархаг аараг, толгод хосолсон нутагтай, мал аж ахуй, газар тариалан эрхлэхэд тохиромжтой. Газар хөдлөлийн 6-7 баллын идэвхтэй бүсэд байршдаг. Гол мөрөн. Нуур 1, булаг шанд 32, рашаан 2, гол горхи 4, 108 энгийн болон инженерийн хийцтэй худагтай.

Баянхонгор аймгийн засаг, захиргаа: Баянхонгор аймаг нь Монгол улсын нутаг дэвсгэрийн баруун төв хэсэгт, нийслэл Улаанбаатар хотоос 630 км зайтай оршдог. Өвөрхангай, Өмнөговь, Говь-Алтай, Архангай, Завхан аймгуудтай нутаг залгаж, БНХАУ-тай 140 км нутгаар хиллэсэн 116 мянган хавтгай дөрвөлжин километр нутагтай. Баянхонгор аймаг нь засаг, захиргааны 20 сум, 103 баг, 1 тосгонтой. 2017 оны байдлаар 87000 хүн амтай, 4 587 738 толгой малтай. Үүнээс ямааныхаа тоогоор улсдаа 1-р байранд, тэмээнийхээ тоогоор 2-р байранд ордог.

Эрүүл мэнд: Суманд 15 ортой 1 эмнэлэг, 1 эмийн сан үйл ажиллагаа явуулж, 1 их эмч, 13 эмнэлгийн тусгай мэргэжилтэн ажиллаж байна. 2012 онд нийт 96 хүүхэд мэндэлж, 0-1 насны хүүхдийн эндэгдэл, эхийн эндэгдэл байхгүй байна. Сумын ард иргэдэд нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх өрөө тасалгаа хүрэлцээгүйгээс сургалт сурталчилгаа явуулах сургалтын өрөө байхгүй.

Боловсрол, соёл шинжлэх ухаан: Монгол улсын төрийн шагналт, гавъяат багш, академич, доктор, профессор Ш.Лувсанвандангийн нэрэмжит ерөнхий боловсролын 12

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМЫН НУТАГТ ОРШИХ “БАРУУН ХАРГАНТЫН” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ
ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

жилийн сургуульд 450 хүүхэд өдрөөр суралцаж, албан бус боловсролын дүйцсэн хөтөлбөрөөр бага, суурь, бүрэн дунд боловсрол нөхөн олгох сургалтанд 35 иргэн суралцаж байна. Бага ангийн хамран сургалт 99,1 хувь, суурь боловсролын хамран сургалт 98,3 хувьд хүрсэн. Ерөнхий боловсролын сургуульд мэргэжилтэй багшийн хангалт 100 хувь байна. Нийт 51 багш, ажилчидтай үйл ажиллагааг явуулж байна.

Аж үйлдвэр: Сумын хэмжээнд төсвийн 6 байгууллага, 17 хоршоо, ХХК зэрэг нийт 23 аж ахуйн нэгж байгууллага үйл ажиллагаа явуулж 12.0 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж орон нутагт 105.0 сая төгрөгийн татвар төвлөрүүлж байна. Тус суманд “Хөх бүрдний эх”, “Их богд” ХХКомпаниуд жилд 60.0 – 1.0 сая тоосго үйлдвэрлэн зах зээлд нийлүүлж байгаа бөгөөд бетон зуурмагны үйлдвэр байгуулахаар “Хаш гоёо” ХХК бүтээн байгуулалтын ажлаа эхлээд байна. Эдийн засгийн голлох салбар нь МАА, газар тариалангийн үйлдвэрлэл юм.

3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛИЙН

3.1 Агаарын чанарт нөлөөлөл үүсгэх эх үүсвэрүүд

“Баруун Харгант” алтнышороон ордыг ашиглах явцад агаарын чанарт нөлөөлөл үүсгэх эх үүсвэрүүд нь:

- Хөрс хуулах, хүдэр олборлох үед тоос, шороо ихээр үүсгэнэ.
- Уурхайн малталтууд болон овоолгын дээд талбайгаас салхинд хийсэх тоос, шороо
- Уурхайн машин техникүүдийн түлшний шаталтаас ялгарах утаа, тортог, хорт хийнүүд
- Ажилчдын суурингаас гарах хатуу шингэн хог хаягдлын бохирдол
- Өрөмдлөг, тэсэлгээний ажил хийх үед гарах тоос, шороо

Хөрс хуулах, түрэх, тээвэрлэх, элс угаах зэрэг бүхий л ажиллагаа тасралтгүй явагдах тул бульдозер, экскаватор, автомашин, бусад төхөөрөмжийн дуу чимээ болон хорт хий утаа гарах, тоос шороо дэгдэх зэргээр агаар орчныг бохирдуулж, хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд сөргөөр нөлөөлнө. Үүнээс гадна барилга угсралтын үйл ажиллагаа болон тээврийн хөдөлгөөнтэй холбоотойгоор агаарын бохирдол үүсч болзошгүй.

3.2 Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл

Баруун Харгант” алтны шороонордыг ил уурхайн аргаар ашиглах төслийн 2 жилийн хугацаанд нийт 11.6 га талбай өөрчлөлтөнд орж хөрсөн бүрхэвч нөлөөлөлд өртөхөөр байна. Төслийн хүрээнд төлөвлөж буй уурхайн барилга байгууламжид хөрс удаан хугацаанд дарагдана. Түүнчлэн дэд бүтцийн барилга, байгууламжийн ойр орчимд машин техник, хүний үйл ажиллагаагаар элэгдэл, эвдрэл, бохирдол их үүснэ. Уурхайн үйл ажиллагааны явцад нүүрс-ус буюу шатахуун, түүнтэй төстэй бүтээгдэхүүн, мөн химийн бодисын асгаралт, шүүрэлтээс хөрс бохирдох боломжтой. Шатахуун болон химийн бодисын агуулах, сав, машин техникийн тээвэрлэлт ачаалалтын үед асгаралт үүсэж хөрсний боломжит бохирдол ихэнхдээ үүсдэг. Асгаралтын хэмжээ, түүний нөхцөл байдлыг зөв үнэлсэн тохиолдолд түүнийн нөлөө бага байдаг, ялангуяа, шаардлага хангасан шатахууны агуулах, асгаралтын хариу арга хэмжээ сайн байхаас хамаарна. Эдгээр арга хэмжээг Аюултай, хортой материалын менежментийн төлөвлөгөөнд тодорхой тусгасан байх ёстой.



Зураг № 7. Төсөл хэрэгжих талбай орчмын хөрсөн бүрхэвч

3.3 Гадаргын болон гүний усан үзүүлэх сөрөг нөлөөлөл

Гадаргын болон газрын доорх усанд нөлөөлөл үүсгэх эх үүсвэрүүд

Төслийн үйл ажиллагааны явцад дараах эх үүсвэрүүдээс гадаргын болон газар доорх усны нөөц, чанарт нөлөөлөл бий болж болзошгүй. Үүнд:

- Хөрс хуулалт болон барилга угсралтын явцад тоосжилт дарахад цэвэр усны нөөц хомсдох
- Уулын малталтын үед хөрсний болон гүний усыг зайлуулж усны нөөц хомсдох
- Барилга угсралтын ажлын явцад барилгын материал хур тунадас болон үерийн усаар угаагдан барилгын материалд агуулагдах бодисууд хөрсөнд нэвчих, улмаар хөрсний бага гүний усыг бохирдуулах
- Баяжуулах үйл ажиллагаа явуулахад химийн бодис алдагдахаас үүдэн хөрсний болон гүний усыг бохирдуулах
- Уулын ажлын болон ахуйн бохир ус хадгалах савыг соруулах үед асгарч газрын хэвлий болон хөрсийг бохирдуулахаас үүдэн хөрсний усыг бохирдуулах
- Уулын ажлын болон ахуйн бохир ус хадгалах сав хүчтэй аадар бороо болон үерийн усаар дүүрч хальхаас үүдэн хөрсөнд нэвчиж хөрсний ус болон бага гүний усыг бохирдуулах
- Техник, тоног төхөөрөмжийн шатах тослох материал алдагдаж хөрсийг бохирдуулхаас үүдэн хөрсний усыг бохирдуулах
- Уурхайн байгууламж, хоосон овоолго, хаягдлын сан, техник хэрэгслийн байршуулалт зэргээр газрын гадаргыг өөрчилж улмаар байгалийн хур тунадас унаж урсац бүрдэх, хөрсний чийг, газрын доорх усыг сэлбэх нөхцөлийг доройтуулах магад.

3.4 Төслийн болзошгүй сөрөг нөлөөлөл үргэлжлэх хугацаа ,эрчим

Байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөлөл, үргэлжлэх хугацаа, эрчим: Уг төслийг хэрэгжүүлснээр байгаль орчны төлөв байдалд үзүүлж болзошгүй нөлөөллийг тогтоохдоо байгаль орчны суурь нөхцөл, судалгаа хийсэн мэргэжлийн судлаачдын дүгнэлтүүдийг үндэслэн тогтоов. Байгаль орчны төлөв байдалд гарч болзошгүй нөлөөлөл, болзошгүй ослын үнэлгээг магадлан жагсаах аргаар тодорхойлов.

Магадлан жагсаах /checklist/ аргаар тооцсон нөлөөллийн үнэлгээ: Үнэлгээ хийгдэж буй төслийн үйл ажиллагаа байгаль орчны төлөв байдал, нийгэм эдийн засагт нөлөөлөх нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчмийг тодруулахын тулд магадлан жагсаах (checklist) аргыг ашиглав. Энэ арга нь нөлөөллийг байна (х), байхгүй (хоосон) гэсэн хэлбэрээр тодорхойлж шууд, шууд бус шинжтэй, удаан, богино хугацаагаар буцалтгүй болон буцаж нөлөөлөх, хүчтэй, дунд болон бага зэрэг эрчимтэй байх зэрэг үзүүлэлтүүдээр авч үзсэн болно.

Төслийн байгаль орчинд сөргөөр нөлөөлөх эх үүсвэрүүдэд дараах хүчин зүйлс орж байна. Үүнд:

- ✚ Хөрс хуулалт
- ✚ Уурхайн олборлох, ачих, буулгах, тээвэрлэх үйл явц.

Төсөл хэрэгжсэнээр тухайн нутгийн байгаль орчны төлөв байдалд үзүүлж болзошгүй нөлөөллийг хүснэгт№ 13-д харуулав..

Хүснэгт № 5 МАГАДЛАН ЖАГСААХ АРГА

№	Байгаль орчны үзүүлэлт	Нөлөөлөл			Хугацаа		Давтамж		Эрчим		
		Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино хугацааны	Удаан хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Бага зэрэг	Дунд зэрэг	Хүчтэй


**БАЯНХОНГОР АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМЫН НУТАГТ ОРШИХ “БАНУУН ХАРГАНТЫН” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ
ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Байгалийн экосистемийн өөрчлөлт										
1	Газрын доорх урсацын өөрчлөлт									
2	Гадаргын усны чанарын өөрчлөлт		x			x	x			x
3	Ургамлан бүлгэмдлийн бүтцийн өөрчлөлт	x				x		x		x
4	Хөрсний элэгдэл, эвдрэл	x				x		x		x
5	Геологийн тогтоцын өөрчлөлт	x				x		x		x
6	Зэрлэг амьтдын орон зайн өөрчлөлт	x				x		x		x
7	Уур амьсгалын өөрчлөлт		x			x		x	x	
Байгалийн нөөцийн ашиглалт										
8	Газрын доорх нөөц баялаг	x				x		x		x
9	Бэлчээрийн байдал	x				x		x		x
10	Эрдэс түүхий эдийн нөөц	x				x		x		x
Байгаль орчны чанарын өөрчлөлт										
11	Агаарын бохирдол	x			x		x			x
12	Ундны усны нөөц хомсдох		x			x		x	x	
13	Хөрсний бохирдол		x			x	x			x
14	Дуу чимээ, шуугианы нөлөөлөл	x			x			x		x
Нийгэмд үзүүлэх нөлөөлөл										
15	Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөл	x				x		x	x	
16	Хүн амын орлого өөрчлөгдөн нэмэгдэх		x			x		x	x	
17	Хүн амын тоо өөрчлөгдөх		x			x		x	x	
Байгалийн цогцолборт газар, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палентлогийн олдвор										
18	Байгалийн өнгө төрх өөрчлөгдөх	x				x		x		x
19	Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх	x				x		x		x
20	Тусгай хамгаалалттай ба цогцолборт газарт нөлөөлөл									
21	Түүх сёлын дурсгалт зүйлд нөлөөлөл									
22	Археологи, палентлогийн олдворт нөлөөлөл									
Эдийн засаг, байгаль орчин										
23	Орон нутгийн орлого нэмэгдэх		x			x		x		x
24	Ажлын байр нэмэгдэх	x				x		x		x
25	Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох		x		x			x		x
Бусад нөлөөлөл										
26	Шороон зам, уурхайн машин механизмын хөдөлгөөн, тээвэрлэлтээс хөрс эвдрэх	x				x	x			x
27	Ахуйн бохир ус, нефтийн бүтээгдэхүүн хөрсөнд нэвчиж, хөрс ба усыг бохирдуулах	x				x	x			x

БАЯНХОНГОР АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМЫН НУТАГТ ОРШИХ “БАРУУН ХАРГАНТЫН” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

28	Ахуйн хаягдал, хогийн цэгийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, шавьж үржих	x			x		x			x	
29	Хүчтэй салхи, уруйн үер	x			x		x			x	
	Дүн	18	8		5	20	7	18	5	15	6

Дээрх хүснэгтээс харахад тус төслийн үйл ажиллагааны явцаас байгаль орчинд нөлөөлөх нөлөөлөл өөр хоорондоо харилцан уялдаа холбоотой нэг нь нөгөөдөө шууд буюу дам байдлаар нөлөөлөх нь харагдаж байна.



Тус ордыг ашиглах төслийн үйл ажиллагаанаас сөрөг нөлөөллийг байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг тус бүрд үзүүлэх ба 7.1% нь “бага”, 45.2% нь “дунд”, 42.8% нь “их”, 4.8% нь “маш их” гэсэн нөлөөллийн үнэлгээний зэрэгт хамаарагдаж байна. Нөлөөлөлд өртөж буй байгалийн бүрэлдэхүүн хэсгүүдээс газрын гадарга, хэвлий нь нөлөөлөлд илүүтэйгээр өртөхөөр байна.

4. 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Баянхонгор аймгийн Өлзийт сумын нутаг дэвсгэрт “Би Эс Ай” ХХК-ийн хэрэгжүүлж буй “Баруун Харгантын” Алтны шороон ордыег ил аргаар ашиглах төслийн үнэлгээний ажлын явцад үйл ажиллагааны товч танилцуулга, эрхлэхээр төлөвлөж буй үйл ажиллагааны тодорхойлолт болон төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн суурь төлөв байдлыг тодруулж үйл ажиллагааны явцад байгаль орчин, хүн амын эрүүл мэндэд үзүүлэх гол сөрөг нөлөөллүүд тэдгээрийн цар хүрээг тооцон сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, багасгах арга хэмжээний зөвлөмжийн хүрээнд энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөг (БОМТ) боловсрууллаа.

Төслийн хэрэгжилтийн явцад барилга байгууламжийн бүтээн байгуулалт, уурхайн олборлолтын үйл ажиллагааны улмаас хамгийн ихээр эвдрэлд орж сөрөг нөлөөлөлд өртөх бүрэлдэхүүн нь хөрсөн бүрхэвч юм. Сөрөг нөлөөллийн цар хүрээ багаас дунд зэрэг ба урьдчилан сэргийлэх болон бүтээн байгуулалтын дараа болон олборлолт дууссан хэсэгт нөхөн сэргээх талаар төлөвлөсөн арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх тохиолдолд нөлөөллийн эрчим эрс буурах боломжтой.

Төслийн ерөнхий үнэлгээний нөхцөлд заагдсаны дагуу байгаль орчныг хамгаалах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар жил бүрийн төлөвлөгөөг БОАЖЯ-ны Сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын дагуу тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг энэхүү тайлангийн 2 жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг (БОМТ) үндэслэн боловсруулж БОАЖЯ-д ирүүлэн батлуулах ба батлагдсан төлөвлөгөөний дагуу гүйцэтгэсэн ажлын тайланг холбогдох газруудад хүргүүлж байх шаардлагатай. Үүнээс гадна тус Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасан Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ), түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь”-ийн дагуу оролцогч сонирхогч талуудыг холбогдох мэдээллээр ханган ажиллах үүргийг төсөл хэрэгжүүлэгч хүлээнэ.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан бөгөөд төслийн 2020 оны менежментийн төлөвлөгөөний ажилд нийт **7,0 сая.төг** зарцуулахаар төсөвлөв.

Хүснэгт № 6 БОМТ-НИЙ ЗАРДАЛЫН ЗАДАРГАА

№	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө	Нийт зардал /мян.төг/
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арилгах арга хэмжээний төлөвлөгөө	1.2
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	1.5
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	1.5
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
6	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	550.0
7	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	550.0
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	680.0
9	Удирдлага зохион байгуулалтын талаар авах арга хэмжээ	800.0
10	БОМТ-ыг оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	220.0
2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал		7.000.000

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМЫН НУТАГТ ОРШИХ “БАНУУН ХАРГАНТЫН” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН
2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт № 7 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн баримт, стандарт
								2023 он	
1	Агаарын чанар								
	Уурхайн олборлолт болон тээврийн Хэрэгслүүдийн үйл ажиллагааны улмаас гарч болох тоосжилтын эх үүсвэрүүд: -Уурхайн олборлолтын үеийн хөрс хуулалт, олборлолт, овоолго хийх газар шорооны ажил, -Уурхайн үйл ажиллагаанд ашиглаж буй тээврийн хөдөлгөөн, Тээвэрлэлтэнд	Уурхайн олборлолтын үе шатанд тоосжилт ихээр үүсэх үед усалгаа хийх	Үйл ажиллагааны турш	-		-	Ү.А-ны зардлаар	Салхи ихтэй үед 7 хоногт 3 удаа, тогтуун үед 2 удаа усалж байх	Агаарын тухай хууль Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ MNS5885:2008 MNS(ISO)13688:2000 MNS3306:1991 MNS5620:2006 MNS5623:2006 MNS5388:2004 MNS5389:2004 Бензинхөдөлгүүрт MNS 5013:2003 Дизель хөдөлгүүрт MNS 5014:2003
		Уурхайд орж гарах машин, ачилт буулгалтын цаг хугацаа, хоорондын зайг тоосны сарнилтай уялдуулан оновчтой байлгах тооцоог хийж мөрдөж ажиллах	Үйл ажиллагааны турш	-		-	Ү.А-ны зардлаар	+	
		Тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг шалгаж, хаалга цонхны чигжээс, хамгаалалтын үзлэгийг хийх	Үйл ажиллагааны турш	-		-	Ү.А-ны зардлаар	+	

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМЫН НУТАГТ ОРШИХ “БАНУУН ХАРГАНТЫН” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН
2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

явж буй машинуудаас ялгарах хорт бодисуудаар орчны агаар бохирдох -Тэсэлгээний ажлын үед үүсэх тоосжилт Ажиллагсад болон нутгийн иргэдийн эрүүл мэндэд нөлөөлөх	Хүнд машин механизмын хөдөлгүүрийн тохиргоо, үйлчилгээг тогтмол байлгах, хөдөлгүүрээс гарах утааны хэмжээг стандартын шаардлага хангах хэмжээнд байлгах арга хэмжээ авах	Үйл ажиллагааны турш	-		-		+		
	Уурхайн ажиллагсдад тоосноос хамгаалах хушуувч, амны маск, хүнсний нэмэлт бүтээгдэхүүнээр ажилчдыг хангах сургалт явуулах	Үйл ажиллагааны турш	-		-	-	+		
2	Хөрсөн бүрхэвч								
Ордын ашиглалтын явцад хөрсний бүтэц найрлагад өөрчлөлт орох, хог хаягдал, тоосжилтоос бохирдол үүсгэх, хүнд даацын машин механизмууд олон салаа зам гаргаж	Өнгөн хөрсийг хуулан авах, хадгалах	Үйл ажиллагааны турш	-		-	Ү.А-ны зардлаар	+	“Газрын тухай” хууль MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга	
	Уурхайн олборлолт явуулж буй хэсгээс баяжуулах үйлдвэр хүртэл тэмдэгжүүлэх	Үйл ажиллагааны турш	-		-		+		

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМЫН НУТАГТ ОРШИХ “БАНУУН ХАРГАНТЫН” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН
2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

<p>хөрс болон ургамлыг гэмтээх.</p> <p>Шатах тослох материал, барилгын материалын хог хаягдал, шатахуун асгарах зэрэг болзошгүй осол аваараас үүдэн хөрсөн бүрхэвчийг бохирдуулах</p>								
<p>Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр тоосжилт үүсэх, сул шороо бүхий газруудаас тоос босох</p>	<p>Төслийн талбай дахь сул шороо бүхий газруудыг ургамалжуулах, мод бут тарих</p>	<p>Төслийн талбайд</p>	<p>-</p>		<p>-</p>	<p>Нөхөн сэргээх арга хэмжээнд тусгав</p>	<p>+</p>	<p>MNS 5914:2008 “Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн шаардлага MNS</p>
<p>3</p>	<p align="center">Усны нөөц, усны чанарт</p>							
	<p>Ажилчдын аюулгүй ажиллагааны дүрэмд усыг ариг гамтай хэрэглэх, хамгаалах тухай тусгаж өгөх</p>	<p>Ажилчдад</p>	<p>-</p>		<p>-</p>	<p>Осол эрсдэлийн менежментийн зардалд</p>	<p>+</p>	
	<p>Ажилчдын унд ахуйн усанд ашиглаж байгаа гүний худагаас дээж авч шинжилгээ хийлгэж,</p>	<p>Ажилчдын байрны хүрээнд</p>	<p>-</p>		<p>-</p>	<p>Орчны хяналт шинжилгээний зардалд</p>	<p>Сард 1 удаа</p>	

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМЫН НУТАГТ ОРШИХ “БАНУУН ХАРГАНТЫН” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН
2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

		усны найрлагыг тодорхойлуулж, ундны усны стандартад нийцэж буйг хянаж байх							
4	Амьтны аймаг, ургамлан нөмрөг								
	Үйл ажиллагаа явуулсантай амьтны нөөц хомсдох, ухсан нүх шуудуунд мал амьтан унахаас сэргийлэх	Уурхайн талбайд мал, амьтан унаж гэмтэхээс сэргийлэх зорилгоор хашаа хамгаалалт хийх	Уурхайн хүрээнд	-		-	240.0	+	
	Хог хаягдлыг ангилан ялгах хогын сав байршуулах	Хог хаягдалыг ил задгай хаяж хүнд ойромсог амьдардаг, хог хаягдлын индикатор амьтад үржих, хордох нөхцөл бүрдүүлэхгүй байх	Уурхайн хог хаягдлын хүрээнд	-		-	Хог хаягдлын менежментийн зардалд	+	Хог хаягдлын тухай хууль 2017 он
	Уурхайгаас алт агуулсан элс олборлох, хөрс хуулах зэрэг ажлын үед ургамал устах, дарагдах талхлагдах зэргээр хамгийн их нөлөөлөлд өртөнө.	Уурхайн тосгоны эргэн тойронд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх	Уурхайн тосгоны хүрээнд	-		-	100.0		
5	Дуу чимээ								

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМЫН НУТАГТ ОРШИХ “БАНГАА ХАРАГАНТЫН” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН
2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

	Нутгийн иргэдийн амгалан тайван байдлыг алдагдуулах	Олборлолтын ажлыг өдрийн цагаар гүйцэтгэх		-		-	-	+	
Нийт			1200.0 сая.төг						

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМЫН НУТАГТ ОРШИХ “БАРУУН ХАРГАНТЫН” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН
2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

БҮЛЭГ 6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт № 8 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал мян,төг	Хэрэгжүүлэх хугцаа ба давтамж	Баримтлах эрх зүй баримт бичиг
	Техникийн нөхөн сэргээлт гадаад овоолго болон дотоод овоолго	2020-2022 оноос үссэн гадаад овоолгыг ил уурхайн ухашруу эөөж нөхөн сэргээлтийн ажил хийнэ.	Төслийн талбайд	га	0,77	-	0,5	-	“Байгаль орчныг хамгаалах тухай” “Ашигт малтмалын тухай”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” MNS5915:2008MNS5916:2008 MNS5917:2008
		Дотоод овоолгоор нөхөн сэргээлт хийж техникийн нөхөн сэргээлт хийнэ		га	1,47	-	0,5	-	
	Биологийн нөхөн сэргээлт	2023 онд техникийн нөхөн сэргээлт хийсний дараагаар шимт хөрсөөр хучиж биологийн нөхөн сэргээлтийг хийнэ.	Төслийн талбайд	Га	1,47	-	0,5	-	
Нийт 1.5 сая.төг									

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМЫН НУТАГТ ОРШИХ “БАРУУН ХАРГАНТЫН” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН
2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

БҮЛЭГ 7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗЫН БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт № 9 Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэрэгжүүлэх давтамж	Хэрэгжүүлэх хугацаа (он), сая.төг	Нийт зардал /сая.төг/	Баримтлах эрхзүйн баримт бичиг, стандарт аргачлал
					2023		
1	ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ						
	Дүйцүүлэн хамгаалах	2022 онд тусгай зөвшөөрлийн талбайд өмнө эвдэрсэн байсан талбайд дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлтийн ажил хийсэн ба тус талбайг үржүүлэх.	Төслийн 3га талбайд	Судалгаа хийх, Санхүүжүүлэх	-	ҮА-ний зардал (ДХ ажлын зардал)	MNS 5914:2015, MNS 4597:2013
2		“Банх”, “Хар нүдэн” нэртэй газарт хувиараа ашигт малтмал олборлогч иргэний эвдрэлд оруулсан 5 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийж өгөх.	Тус нэрлэсэн газарт 5 га		-	1,0	
3	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд	Дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлт хийсний дараа 500-ш мод тарих	Төслийн 3га талбайд			0,5	
		Аймаг орон нутгийн саналын хүрээнд 2023 онд 1000 аас доошгүй мод тарьж, хайс хамгаалалтын асуудлыг шийдэх.	Төслийн талбайд 3 га				
	Нийт дүн, мян.төг		1.5 сая.төг				

БҮЛЭГ8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

2023 онд тухайн төслийн уурхайлалтын болон эрчимтэй сөрөг нөлөөллийн бүсэд иргэд, оршин суугчид, айл өрх байхгүй байна. Иймд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө тусгагдаагүй болно.

БҮЛЭГ9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төсөл хэрэгжих бүс нутаг, түүний орчимд хийсэн археологийн судалгаа, түүх соёлын өвийн судалгааны дүн, түүх, соёлын өв дурсгалуудын талаарх нутгийн иргэд, холбогдох байгууллагын мэдээлэлд үндэслэн түүх, соёлын өв дурсгалуудыг хамгаалах төлөвлөгөө боловсруулна. Уурхайн ашиглалтын үйл явцад түүх соёлын дурсгалт зүйлс олдвол уурхайн үйл ажиллагааг түр зогсоон зохих байгууллагад мэдэгдэж, түүх соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах ажлыг зохион байгуулах болно.

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМЫН НУТАГТ ОРШИХ “БАНУУН ХАРГАНТЫН” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН
2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

БҮЛЭГ 10. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.

Хүснэгт № 10 Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал	Нийт зардал (мян\төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Цаг агаарын үзэгдэл, ажилчдын хариуцлагагүй байдлаас шалтгаалан осол гарах	Галын болон байгалийн аюул гамшигаас урьдчилан сэргийлэх, арга хэмжээний талаар сургалт зохион байгуулах	Нийт ажиллах хугацаанд уурхайн бүх ажилчдад	-	Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээнд тусгагдсан		2023 он	Гамшгаас хамгаалах тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
	Осол эрсдэл үүссэн үед устгах арга хэмжээний төлөвлөгөөтэй байх	Төслийн бүхий л үед хэрэгжүүлэх ХХАА-ны гарын авлагатай болох	-	Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээнд тусгагдсан		2023 он	
	Болзошгүй аюул ослын үед ашиглах багаж хэрэгсэл холбооны хэрэгсэлтэй болох	Ус, элс, шороо, хүрз цэвэрлэгээний бодис, холбооны хэрэгсэл гэх мэт	2	200		2023 он	
Болзошгүй осол, саатал, техник технологийн шугам сүлжээний гэмтэл, галын гэнэтийн аюул үүсэх, байгалийн гамшиг	Техник, технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах, Машин техникийн үйлчилгээ засварыг тусгай бэлтгэсэн талбайд явуулж хэвших		-	220		2023 он	
	Галын болон байгалийн аюул гамшигаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт, зохион байгуулах		12				
	Аваар ослын үед авран хамгаалах төлөвлөгөөтэй байх		-				
	Байгаль орчныг хамгаалах талаар сургалтыг жилд нэг удаа зохион байгуулах, холбогдох сумын байгаль орчны алба, байгаль хамгаалагч нартай харилцан холбоотой ажиллах		-				
Эрүүл мэнд	Ажилчдыг ажлын хувцас хамгаалалтын тусгай хэрэгслээр (хөвөн даавуун материалаар хийсэн хувцас, резинэн хормогч, резинен гутал, бээлий, хамгаалалтын нүдний шил маск) хангах		Бүх ажилчдад	220.0		2023 он	
	Хүний эрүүл мэндэд үзүүлэх эрсдлийг нарийвчлан мэргэжлийн байгууллагаар тогтоолгох		Төслийн нийт хугацаанд	220		2023 он	
Нийт зардал (мян.төг)				550.0			

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМЫН НУТАГТ ОРШИХ “БАРУУН ХАРГАНТЫН” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН
2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

БҮЛЭГ 11. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт № 11 ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийг хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Төсөл хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт, стандарт
							2023 он	
Хог хаягдлыг тогтмол зайлуулаагүйгээс орчин бохирдол	Хог хаягдлын хор уршиг, ангилан ялгах талаар ажиллагсдад сургалт явуулах, хог хаягдлын мэдээллийн сангийн бүртгэл хөтлөх	Үйл ажиллагааны турш				100.00	+	Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага MNS 5344:2011
Ахуйн хатуу хог хаягдлаар газрын гадарга бохирдох;	Ахуйн хог хаягдлаа эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулан тээвэрлүүлнэ.	Төслийн талбайн бүх барилга байгууламжуудад				100.00	+	Хог хаягдлын тухай хууль
Хог хаягдал, ШТМ-ын хаягдал хурын усаар дамжин гүний усыг бохирдуулах	Унд ахуйн усыг лабораторын шинжилгээнд тогтсон хуваарийн дагуу шинжлүүлж байх	Төслийн талбай дахь худгийн усанд				ОХШХ-т тусгасан аар	+	MNS 3936:1986 Ундны ус болон үйлдвэрийн ус-Тухайн талбарт нь шинжилгээ хийх MNS 0900:2005 Ундны ус.

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМЫН НУТАГТ ОРШИХ “БАНУУН ХАРГАНТЫН” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН
2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

								Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ
Стандарт нийцсэн усаар хангах	Ундны усны стандарт хангасаар усаар ажилчдад үйлчлэх	Ундны усны хүрээнд				125.00	+	Ундны ус. Эрүүл ахуйн шаардлаг түүнд тавигдах шаардлага MNS 0900:2018
Ахуйн хаягдлыг ил задгай хаяхгүй байх харьяа нийтийн үйлчилгээний албатай хог хаягдлын гэрээ хийх	Ахуйн хатуу, шингэн хаягдлыг ил задгай хаяхгүй байх, ажилчидын бие засах газар болон бохир ус хуримтлуулах цэгийг холбогдох хууль, стандартын шаардлагад нийцүүлэн хүрээлэн буй орчныг бохирдуулахгүй байхаар төлөвлөн шинээр байгуулах, үүссэн шингэн хаягдлыг богино хугацаанд нутаг дэвсгэрээс зөвшөөрөгдсөн цэг рүү зайлуулах	Ахуйн хаягдлын хүрээнд				50.0	+	Усны тухай хууль, 2012 он Гүний усыг бохирдолоос хамгаалах ерөнхий шаардлагууд. MNS 3342:1982
	Зуны улиралд хогийн сав болон ажилчдын амьдрах байр. Гал тогоонд хортон шавьжийн ариутгал халдваргүйжүүлэлт хийлгэх					155.0		
Нийт		550.0 мян.төг						

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМЫН НУТАГТ ОРШИХ “БАРУУН ХАРГАНТЫН” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН
2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

БҮЛЭГ12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Хүснэгт № 12 Орчны хяналт шинжилгээ

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байгаль бүрэлдэхүүнд нөлөөлөл үзүүлэх	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа ба давтамж 2023 он	Давтамжийн тоо	Нэгжийн зардал (мян.төг)	Нийт зардал (мян.төг)	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
Хөрсний бохирдол								
1	Хөрсний морфологи бичиглэл, рН, цахилгаан дамжуулалт, давс %, ялзмагийн агууламж %, шим тэжээлийн элемент, хөрсний механик бүрэлдэхүүн, нүүрс устөрөгчийн нэгдлүүд	Хөрс элэгдэл эвдрэлд орох, үржил шимээ алдах, гадаргын унаган хэлбэр өөрчлөгдөх	Төслийн талбайд 2 цэг сонгох /Уурхайн кемп орчим, уурхайн ухаш/	Хагас жил тутамд	Жилд 2 удаа	15.0	2 цэгт х 2 дээж х жилд 2 удаа х 1 жил /15.0/ НИЙТ 120,0 /Хөрсний химийн шинжилгээ 1 дээж - 15.0 төг,	MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, MNS 3309:1991 Хөрс. Хөрсний хялбар уусдаг давсны химийн найрлагыг тодорхойлох арга, MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга, MNS 4006:1987 Хөрс. Хөдөлгөөнт фосфор, калийг тодорхойлох Мачигины арга MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага MNS ISO 11047:2001 Хөрсний чанар. Хөрсний усан орчны хандмалд кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайрыг тодорхойлох. Дөлний болон цахилгаан дулааны атомын шингээлтийн спектрометрийн арга
	Хүнд металлын агууламж	Түлш, тосолгооны материал болон химийн бодис, хог хаягдлаар хөрс бохирдох	2 цэгт /Засварын цех, ШТС/	Хагас жил тутамд	Жилд 2 удаа	20.0	2 цэгт х 2 дээж х жилд 2 удаа х 1 жил х 20,0 Нийт 160,0 хүнд металлын	MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга MNS 5850:2008 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМЫН НУТАГТ ОРШИХ “БАНУУН ХАРГАНТЫН” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН
2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

								шинжилгээ 1 дээж- 20.0 төг/	
Усны хяналт шинжилгээ									
2	Усны чанар рН, ууссан нийт давс (жингийн аргаар), усны ерөнхий болон хүнд металлын шинжилгээ	Төслийн талбай орчим	Унд ахуйн усыг хангаж буй уснаас	2023 он	Жилд 2 удаа	40.0	40.0*2 удаа х 1жил НИЙТ 80.0	MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS (ISO) 5667-14:2000 Гадаад орчны уснаас сорьц авах болон тээвэрлэх, гарын авлагын зөвлөмж MNS 13.060.50 Усны чанарын стандарт MNS 0900 : 2005 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт	
3	Усны түвшин усны ундарга нөөц	Ус ашиглалтаас, зарцуулалтаас газар доорх усны горим өөрчлөгдөх	Гүний худгийн ус, Гол	2023 он					
ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН 2023 ОНЫ ЗАРДЛЫН ДҮН							680.0		

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМЫН НУТАГТ ОРШИХ “БАНУУН ХАРГАНТЫН” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН
2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

БҮЛЭГ13. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР АВАХ АРГА ХЭМЖЭЭ

Хүснэгт № 13 БОМТ-ийн ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Нэгжийн өртөг мян.төг	Зардал мян.төг	Хугацаа 2023 он
1	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх шинэчлэн засварлах	Уурхайн хэмжээнд	Дотоод зохион байгуулалтаар		2023 он
2	Байгаль орчныг хамгаалах, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар удаа сургалт, сурталчилгааны ажлыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран зохион байгуулах.	Уурхайн хэмжээнд	Удирдлагын түвшинд		2023 он
4	Байгаль хамгаалах талаар хийсэн ажлыг жил бүрийн тайланг БОАЖЯ болон сумын ЗДТГ-т хүргэн өгч байх	Уурхайн хэмжээнд	Дотоод зохион байгуулалтаар		Жил бүрийн 12 сард
5	Байгаль хамгаалахад сум багийн холбогдох ажилтнуудын оролцоог идэвхижүүлэх, уулзалт зөвлөгөөг жил бүр зохион байгуулах, тэдний санал зөвлөмжийг БОМТ-нд тусгах	Уурхайн хэмжээнд	Удирдлагын түвшинд		2023 он
6	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөл сайжруулах арга хэмжээний төлөвлөгөө	Уурхайн хэмжээнд	Дотоод төлөвлөлтөөр		2023 он
7	Яаралтай анхны тусламжид шаардлагатай эм тариа, багаж хэрэгслийг бэлтгэж, шаардлагатай газруудад байрлуулах	Уурхайн хэмжээнд	-	250.00	2023 он
8	Хөдөлмөр хамгаалал эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах сургалт зохион байгуулах, галын аюулгүй ажиллагааны талаар дүүргийн ГТТХХэлтэстэй хамтран галын аюулаас урьдчилан сэргийлэх үзүүлэх сургууль хийх	Уурхайн хэмжээнд	Ослын сургалттай хамтран хэрэгжүүлэх		3-р улирал

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМЫН НУТАГТ ОРШИХ “БАНУУН ХАРГАНТЫН” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН
2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

9	ХАБЭА дүрмийн дагуу үзлэг, шалгалтыг тогтмолжуулж илэрсэн зөрчлийг тухай бүр арилгах ажлыг зохион байгуулах	Уурхайн хэмжээнд	Дотоод зохион байгуулалтаар		Улирал бүр
10	Ажилчдыг шаардлагатай хувцас, тусгай хамгаалах, амны хаалт, малгай зэргээр хангах	Уурхайн хэмжээнд	Дотоод зохион байгуулалтаар		Жил бүр
11	Яаралтай анхны тусламжид шаардлагатай эм тариа, багаж хэрэгсэлд зарцуулах зардал	Уурхайн хэмжээнд	50.0	100.0	Жилд 2 удаа
12	Галын аюулгүй байдлын дүгнэлтийг дүүргийн Онцгой байдлын хэлтсээр гаргуулах	Дотоод төлөвлөлтөөр			Жилд 1 удаа
13	Нийгмийн хариуцлагын хүрээнд багын иргэдэд цагаан сар болон бусад үйл ажиллагааг дэмжих үүднээс тусламж өгөх	Нийгмийн хариуцлагын хүрээнд хийсэн гэрээгээр			2023 он
14	Байгаль орчны хуваарьт аудитыг мэргэжлийн байгууллагаар хийлгэх.	Уурхайн хэмжээнд			2023 он
Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт зардал				800.0 мян.төг	

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМЫН НУТАГТ ОРШИХ “БАНУУН ХАРГАНТЫН” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН
2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

**БҮЛЭГ14. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ОРОЛЦОГЧ, СОНИРХОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ,
ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ХУВААРЬ**

Хүснэгт № 14 БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь

БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх оршин суугчид, оролцогч талууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээний агуулга	Хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Зохион байгуулах албан тушаалтан	Зохион байгуулах газар
БОМТ-ний биелэлтийн үр дүнгийн тайланг төсөл хэрэгжиж буй Баянхонгор аймгийн сумдын ажлын хэсэгт танилцуулах	БОМТ-ний биелэлтийн тайлан боловсруулж сумын засаг захиргаанд хүргүүлнэ	Тайланг хүлээн авсан актыг хүргүүлэх	2023.11.01-нд хүргүүлэх	-	“БИ ЭС АЙ” ХХК ” ХХК-ын байгаль орчны мэргэжилтэн	
Нийт		220.0 мян.төг				